

ТАНИЛЦУУЛГА

Журам батлах тухай Засгийн газрын
тогтоолын төсөл боловсруулсан тухай

2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд "Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичиг болон үйлдвэрлэлийн ослын акт буюу мэргэжлээс шалтгаалсан өвчний тодорхойлолтыг бүрдүүлнэ" гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журмыг нийгмийн даатгалын төв байгууллага тогтооно" гэж тус тус заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр "Журам батлах тухай" тушаалыг мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална" гэж заасан.

Иймд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2022 онд хөдөлмөрийн чадвар алдсан 3568 тэтгэвэр авачид 27.5 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсан 463 иргэнд 3.4 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1166 иргэнд 1.3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. 2023 оны 8 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн чадвар алдсан 3515 тэтгэвэр авагчид 19.7 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсан 463 иргэнд 2.6 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 967 иргэнд 1.1 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 244.4 тэрбум төгрөг, зарлага 58.9 тэрбум төгрөг, үүнээс оршуулгын тэтгэмжид 606 сая төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойпгож мөрдөх ба тогтоолыг хэрэгжүүлэхэд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ